

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 260

Улаанбаатар хот

“Финанс линк групп” ХХК-ийн брокер, дилер,
андеррайтерийн тусгай зөвшөөрлийн тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Финанс линк групп” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.
2. “Финанс линк групп” ХХК-ийн үнэт цаасны зах зээл дээр андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-г, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ